

2-р хичээл: Хамтдаа зөвлөлдөх нь

Та энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл богино хэсэгт хуваан зааж болно. Хичээлийг заахдаа тухайн орон нутгийнхаа нөхцөл байдал, чуулга эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө хэрэгцээ, нас, ойлголтод тулгуурлаарай.

ХАМТДАА ЗӨВЛӨЛДСӨНӨӨР ХҮЧ ЧАДЛЫГ ХҮЛЭЭЖ АВДАГ

Их Эзэн Өөрийн Сүмийг зөвлөлөөр дамжуулан удирддаг (Сургаал ба Гэрээ 43:8–10-ыг үзнэ үү). Хамтдаа зөвлөлдөх нь чуулга, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийг нэгтгэж, Сүнсээр удирдуулсан шийдвэрүүдийг гаргаж, Их Эзэний ажлыг илүү үр дүнтэй гүйцэтгэхэд бидэнд тусалж чадна. Хамтдаа зөвлөлдөх нь илүү сайн шийдвэр гаргахад бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

ХАМТДАА ЗӨВЛӨЛДӨХ НЬ БИДЭНД ИЛЧЛЭЛТ ХҮЛЭЭН АВАХАД ТУСАЛЖ ЧАДНА

Ахлагч Нийл Л.Андэрсэн “илчлэлт бидний дунд тархсан” хэмээн заасан (in “Auxiliary Panels Use New Training Library,” *Ensign*, Apr. 2011, 76). Зөвлөлдөх нь бидэнд Их Эзэний ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх явцдаа тэрхүү тархсан илчлэлтүүдийг цуглуулах боломжийг олгодог. Энэхүү санааг үлгэрлэн үзүүлэхийн тулд та ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бүрд цөөн хэдэн ангийн таавар өгч, тааврыг гүйцээхэд хамтран ажиллахыг урьж болно.

- Энэхүү жишээ нь ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд хамтдаа зөвлөлдөхтэй хэрхэн холбогдож байна вэ?
- Яагаад хүн бүр зөвлөлд хувь нэмрээ оруулах нь чухал вэ?
- Бид хүн бүрийг оролцохдоо таатай байлгахын тулд юу хийж болох вэ?
- Бид хамтдаа зөвлөлдөхдөө Ариун Сүнсийг урьж, сонсохын тулд юу хийж болох вэ?

Та чуулга болон ангид тулгарч байгаа хэрэгцээ, бэрхшээлийн талаар бодож үзээрэй. Үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар хамтдаа зөвлөлдөх дадлага хий.

НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- Матай 18:20
- Ифер 2:14–3:16
- Сургаал ба Гэрээ 88:122
- Сургаал ба Гэрээ 107:84–87
- M. Russell Ballard, “Strength in Counsel,” *Ensign*, Nov. 1993, 76–78
- *General Handbook: Serving in The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 10.4, 11.3.4, ChurchofJesusChrist.org